



XII/2021

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 13




## Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 300.0 мянган төгрөг байна

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 12 дугаар сард атны үнэ 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 7.1 мянган төгрөгөөр, хязаалан гунынх 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 900 төгрөгөөр, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 900 төгрөгөөр тус тус өссөн байна.


Эр хонины үнэ 207.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 800 төгрөгөөр, эр ямааны үнэ 150.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.3 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), 2021 оны 12 дугаар сард, мянган төгрөгөөр




Эр хонины 2021 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй, Дорнод аймагт хамгийн бага буюу 170.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 10.1 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 12 дугаар сард



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 12 дугаар сард боодолтой өвсний (20 кг) үнэ Архангай аймагт хамгийн их буюу 15.0 мянган төгрөг, Сэлэнгэ, Дорнод аймагт хамгийн бага буюу 3.5 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 12 дугаар сард



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2021 оны 12 дугаар сард 8.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.4 мянган төгрөгөөр өсөж, харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 99.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 800 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 12 дугаар сард, төгрөг



Хивэгний (25 кг) үнэ 2021 оны 12 дугаар сард Хэнтий аймагт хамгийн их буюу 26.0 мянган төгрөг, Орхон аймагт хамгийн бага буюу 18.0 мянган төгрөг байна.

**Тооцох аргачлал:**

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



**Эх үүсвэр:**

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ гархаах хуваарь:**

2022 оны 2 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын

Үнийн статистикийн хэлтсийн гэрээт

ажилтан Б. Оргил

Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212